



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 0/280

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2020 оны А/428 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Саммит компьютер технологи” ХХК нарын байгуулсан Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт “Хот байгуулалтын мэдээллийн сангийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ” НХААГ/202004626 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт “Хот байгуулалтын мэдээллийн сангийн тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /С.Сэржжаргал/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115070000697

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны 06 дугаар сарын 15 өдрийн  
0/280 дугаар тушаалын хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: С.Сэржжаргал Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Ганбаяр Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Алтансоёмбо “Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газрын Хот байгуулалт мэдээлэлийн хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Ш.Отгонтуяа Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газрын Захиргаа, санхүүгийн хэлтэсийн эд хариуцагч /зөвшилцсөнөөр/

Э.Өлзийбүрэн Саммит компьтер технологи ХХК-ний борлууллалтын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ч.Чулуунтөгс Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн